

С. Чимиддамба
Д. Пүрэв

БНМАУ, АЗИ ТИВИЙН ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛД

БНМАУ-ын засгийн газрын энхийг эрхэмлэгч гадаад бодлогын үндсэн зорилтын нэг бол Ази тивд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахын төлөө тэмцэл билээ. МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэлдээ нөхөр Ю.Цэдэнбал «Азид энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, энэ тивийн ард түмэн, орнуудын хооронд сайн хөршийн хэвийн харилцааг хөгжүүлэх асуудлыг манай нам байнга онцгой анхаарч байдаг нь бүрэн зүйн хэрэг юм»¹ гэж онцлон тэмдэглэсэн юм.

Манай улс Ази тивийн ихэнх оронд үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын хөдөлгөөн ид өрнөж байсан бүр 40-өөд оны сүүлчээс эхлэн азийн ард түмний шударга тэмцлийг тууштай дэмжиж, тэдэнтэй эв санааны нэгдэлтэй явж ирэв. Дэлхийн II дайнд зөвлөлтийн зэвсэгт хүчин фашист Герман, милитарист Японыг бут цохиж түүхэн ялалт байгуулсны үр дүнд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүхэнд шинэ үе эхэлсэн билээ. Зөвлөлт Холбоот улс олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний шууд тусламж дэмжлэгийн ачаар хятадын хувьсгал ялсны дүнд БНХАУ байгуулагдан, Британийн колони байсан Энэтхэг улс улс төрийн тусгаар тогтнолоо зарлан тунхаглаж ардчилал, дэвшлийн замд шилжин орж, мөн Азийн бусад олон орон тусгаар тогтнолоо олсон нь манай гаригийн энэ бүс нутагт энх амгалан аж төрөх сайхан нөхцлийг бий болгосон билээ.

Империализм, колониаллолын бодлогын эсрэг үндэсний тусгаар тогтнолынхоо ололт амжилт, Азид энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө зохион байгуулалттай тэмцлийн эх үндсийг тавьсан Бандунгийн үзэл санааг БНМАУ-ын засгийн газар урьдын адил одоо ч туйлбартай дэмжиж байгаа билээ.

Сүүлийн жилүүдэд Ази тивд тухайлбал Энэтхэг-Хятадын хойгт социализмын байр суурь өсөн бэхжиж байгаагийн зэрэгцээ Ази тивийн улс түмэн империализм, Бээжингийн жанжлал, харгис хүчний эсрэг үндэсний болон нийгмийн эрх чөлөө, дэвшил хөгжлийн төлөө тэмцэлдээ шинэ шинэ амжилт олсоор байна. Энэтхэг-Хятадын хойгийн ард түмэн америкийн империализмын эсрэг явуулсан олон жилийн дайнд баатарлаг гавъяа байгуулсны дүнд нэгдмэл, социалист Вьетнам улс мөн Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Кампучи Ард Улс байгуулагдсан нь социализм, энх тайван, ардчилалын хүчийг Зүүн өмнөд Азид нухчин дарах гэсэн империализм, жанжлах үзэлтний түрэмгий бодлогод том цохилт болов.

Афганистанд ардчилсан хувьсгал ялж, Афганы ард түмэн олон зуун жилийн феодалын хоцрогдлоос ангижрах боломжтой болж, Ираны ард

¹Ю. Цэдэнбал. Монгол Ардын Хувьсгалт Намын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан, ойрын жилүүдийн зорилт. Улаанбаатар. 1981 он.

түмэн империализм, хааны харгис дэглэмийг таягдан хаяж, Азийн зарим оронд нийгэм-эдийн засгийн дэвшилт өөрчлөлт гарсан нь Ази тивийн байдлыг тогтворжуулах таатай нөхцлийг бүрдүүлэв.

Азийн олон орон багтдаг, БНЭУ болон Ази, Африкийн хэд хэдэн орны санаачилсан эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний байр суурь улам бүр бэхжиж, империализм, хятадын жанжлах хүчний эсрэг, энх тайван, аюулгүй байдал, дэвшил хөгжлийн төлөө Ази, Африк Латин америкийн ард түмний тэмцэлд зохих хувь нэмрээ оруулсаар байна.

БНМАУ-ын засгийн газар, ард түмэн Ази тивийн томоохон гүрэн Бүгд Найрамдах Энэтхэг Улстай Монгол-Энэтхэгийн 1973 оны хамтарсан тунхаглалын зарчимт үзэл санааны дагуу найрамдал, хамтын ажиллагаагаа амжилттай хөгжүүлж байгаа нь Азид энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх нийтийн үйл хэрэгт бүрэн дүүрэн нийцэж байна. Манай улс Ази тивийн бусад улсуудтай улс төрийн болон соёлын харилцааг тууштай хөгжүүлэн тус тивд энх тайван, тогтвортой байдлыг сахин хангахад чиглэсэн асуудлыг оролцуулан хоёр талын сонирхож байгаа олон улсын зангилаа асуудлаар санал бодлоо тогтмол солилцож ирсэн нь Ази тивийн аюулгүй байдлыг хамтын хүчин чармайлтаар хангахад чухал ач холбогдолтой юм.

Гэвч дэлхийн империалист харгис хүчин, хятадын жанжлах үзэлтнүүд эвсэлдэн сүлбээлдэж алдагдсан байр сууриа нөхөн авч ноёрхлоо тогтоохын тулд Ази дахь социализм, үндэсний тустаар тогтнол, нийгмийн эрх чөлөөний төлөө тэмцлийн эсрэг зүсэн бүрийн дайсагнасан хорт явууллагаа сүүлийн үед улам бүр идэвхжүүлж байна. Энэ нь Азийн янз бүрийн бүсэд хэвийн байдлыг алдагдуулан хурцатгах, улмаар дайн дажны гал голомтыг бий болгох ноцтой хүчин зүйл болж байна.

Америкийн колоничлогчид Вьетнамын баатарлаг ард түмний олон жилийн шударга тэмцэлд ялагдаж, Зүүн өмнөд Ази дахь өөрийн нөлөөний хүрээг алдсаны дараа Бээжингийн эрх баригчид жанжлах санаархлаа хэрэгжүүлэхийг элдэв аргаар оролдож америкийн империализм, японы милитаризмын харгис хүчинтэй цэрэг стратегийн эвсэл холбоо бай- гуулах бодлогыг хүчтэй явуулах болсон нь Ази тивийн одоогийн байдлыг бүр ч ноцтой хүндрүүлж байгаа юм.

Ази дахь олон улсын иймэрхүү түгшүүргэй нөхцөлд тус тивийн энх тайван, аюулгүй байдлыг хамтын хүчээр хамгаалан бэхжүүлэх явдал урьд урьдаас улам чухал болж байна. Азийн аюулгүй байдлын төлөө нийтийн их тэмцэлд ЗХУ-ын оруулж байгаа хувь нэмрийг онцлон тэмдэглэвээс зохино.

ЗХУКН-ын XXVI их хурал дээр ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга нөхөр А. И. Брежнев «Дайны аюулыг устгах, олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэхийн тулд илүү шинэ хүч, чармайлт гаргахыг өнөөдөр дэлхий дахины байдал шаардаж байна»² гэж цохон тэмдэглээд уг зорилтыг үндэс болгож, тухайлбал ЗСБНХУ, Хятад, Япон зэрэг гүрнүүд айл хөрш оршдог Алс Дорнодод итгэлцлийн уур амьсгал бий болгох явдлын чухалтай холбогдуулан Алс Дорнодод итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээний талаар сонирхогч бүх оронтой хэлэлцээ хийхэд ЗХУ бэлэн байгаа тухай үнэтэй шинэ санал дэвшүүлэн тавьлаа.

Азид энх тайван, тогтвортой байдлыг бий болгох, итгэлцлийг бэхжүүлэх талаар ЗХУ-аас өрнүүлж байгаа тэмцэлд өөрийн зүгээс бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэхийн тулд БНМАУ улс төрийнхөө га-

²Л. И. Брежнев. ЗХУКН-ын Төв Хорооны тайлан, намын дотоод гадаад бодлогын ээлжит зорилт. УБ. 1981. 45-р тал.

даад бодлогын үйл ажиллагааг бүрэн чиглүүлсээр байгаа юм. Азид хамтын аюулгүй байдлыг хангах тухай зөвлөлтийн санаачлагыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгоор Азийн социалист орон БНМАУ уйгагүй хүч чармайлт тавихын зэрэгцээ дайн түрэмгийлэл гарах ямар нэг боломжийг үгүй болгох асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэхүйц ач холбогдолтой тодорхой саналыг тухай бүр дэвшүүлсээр ирэв.

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю.Цэдэнбал 1973 онд МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурал дээр хэлсэн үгэндээ Азийн улсуудын хооронд хоёр талын болон бүс, районы хэмжээнд хүч хэрэглэх болон түүнийг хэрэглэхээр далайлган сүрдүүлэх явдлаас татгалзах, үл довтолох тухай гэрээ хэлэлцээр байгуулах үзэл санааг анх дэвшүүлсэн билээ.

1981 оны 5-р сард хуралдсан МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэлд орчин үеийн олон улсын байдал ялангуяа Азийн байдалд зарчмын дүн шинжилгээ өгч улмаар тус улсын энх тайванч гадаад бодлогын үндсэн зорилтуудыг тодорхойлов. Нөхөр Ю.Цэдэнбал МАХН-ын XVIII их хуралд тавьсан тайлан илтгэлдээ: «Америкийн империалистууд, Бээжингийн жанжлагчид зөвлөлтийг эсэргүүцэх, со-циализмыг эсэргүүцэх үндсэн дээр улам нягт сүлбээлдэж байна. Тэд улс түмний энх тайван, эрх чөлөө, тусгаар тогтнолын эсрэг хуйвалдаж, социалист орнууд, дэвшилт хөгжлийн замд орсон улс, ард түмний эсрэг дайсагнасан явууллагаа уялдуулан үйлдэж байна»³ гэж тэмдэглэсэн юм.

Олон улсын байдал, ялангуяа Ази тивийн энх тайван, аюулгүй байдлыг нийтийн хүчээр хамгаалж бэхжүүлэх хүсэл эрмэлзлэлийг удирдлага болгон, Монголын ард түмний энхийг эрхэмлэгч хүсэл зоригийг илэрхийлэн МАХН-ын XVIII их хурлын хүндэт индрээс нөхөр Ю.Цэдэнбал Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц боловсруулж байгуулах саналыг дэвшүүлсэн билээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю.Цэдэнбалын тодорхойлж хэлснээр Алс Дэрнодод итгэлцлийн арга хэмжээг боловсруулах тухай ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлсэн санал болон Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц боловсруулж байгуулах манай энэ санал нь бие биедээ харилцан нэмэр болж нийтийн ариун үйлсэд үйлчлэх нь эргэлзээгүй юм.

МАХН-ын XVIII их хурлаас дэвшүүлсэн Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах саналыг хэрэгжүүлэх зорилгоор 1981 оны 6-р сарын 29-нд хуралдсан БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганаас Ази, Номхон далайн бүх орны парламентад хандаж Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх уриалга гаргав. Энэ уриалгад: «Дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, бат бэх энх тайван тогтоох, манай тивийн улсуудын хооронд харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхийн төлөө тэмцэлд хүч чармайлтаа нэгтгэхийг бид Ази, Номхон далайн бүх орны парламентууд тэдгээрийн гишүүдэд уриалж байна.

...Азийн энх тайван аюулгүй байдлын хойшлуулшгүй асуудлыг шийдвэрлэхийн тулд энэ тивийн бүх орны хооронд улс төрийн өргөн уулзалт хэлэлцээ хийж, харилцан итгэх, ойлголцох уур амьсгал бий болгох нь

³Ю. Цэдэнбал. Монгол Ардын Хувьсгалт намын XVIII их хуралд тавьсан намын төв хорооны тайлан, ойрын жилүүдийн зорилт, Улаанбаатар. 1981 он. 21-р тал.

чухал гэж бид үзэж байна. Нийгмийн янз бүрийн байгууламжтай улсууд энх тайвнаар зэрэгцэн оршихоос өөр ухаалаг зам байхгүйн нэгэн адил өнөөдөр улс төрийн уулзалт хэлэлцээнээс өөр арга зам байхгүй юм»⁴ гэжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганаас гаргасан дээрх уриалгыг БНМАУ-ын засгийн газар, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүн, Ази, Номхон далайн 50 гаруй орны төр, засгийн газрын тэргүүн нарт илгээж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн албан ёсны баримт бичиг болгон тараасан бөгөөд манай энэ чухал санаачлагыг олон улс гүрнүүд ойлгон хүлээн авч өөрсдийн нааштай хариуг ирүүлсний дотор НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын нааштай хариу илгээлт орж байна.

Энх тайван, аюулгүй байдлын төлөө гарамгай тэмцэгч нөхөр Л. И. Брежнев илгээлтийн үзэл санааг бүрэн дүүрэн дэмжиж н. Ю.Цэдэнбалд ирүүлсэн хариундаа «...Эдгээр санал, бодол цаг үеэ олсон чухал зүйл гэж үзэж байна. Империалист жанжлагч харгис хүч тус нутагт хуучин зөрчил зөрөлдөөнийг хурцатгах, шинэ зөрчил мөргөлдөөн дэгдээж, түгшүүртэй байдлыг байнга дэвэргэж байгаа нөхцөлд БНМАУ-ын санаачлага цаг үеэ олсон чухал зүйл гэж үзэж байна»⁵ гэж үнэлээд ЗСБНХУ БНМАУ-тай хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн нь МАХН-ын XVIII их хурлаас ёс төртэй тунхаглан дэвшүүлсэн саналыг хэрэгжүүлэхэд олон улсын зарчмын чухал ач холбогдолтой дэмжлэг болов. Энэ талаар нөхөр Ю.Цэдэнбал өгүүлсэн нь «...дэлхий дахины байдлыг түгшүүртэй болгох, энх тайван, намжмал байдлын төлөө улс түмний тэмцлийг сулруулах, зэвсэглэлээр хөөцөлдөх аюултай урхинд улс түмнийг татан оруулах гэж улайран зүтгэж буй империалист жанжлагч хүчний эсрэг манай нийтийн тэмцэлд биднийг зоригжуулж байна»⁶ гэжээ.

Олон улсын байдал, түүний дотор Ази тивийн өнөөгийн ээдрээтэй байдлыг сайжруулан тогтворжуулах зорилгоор социалист ертөнцийн зүгээс удаа дараа гаргаж байгаа тодорхой санаачлагын нэг бол 1982 оны 3-р сарын 24-нд Зөвлөлт Бүгд Найрамдах Узбек улсад Лениний одон гардуулахад зориулан Ташкент хотноо хийсэн баярын хурал дээр ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Л. И. Брежневээс дэвшүүлсэн санал болно. Дэлхийн цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, зэвсгээр түүний дотор Европ дахинд пуужин-цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдлыг хазаарлан зогсоох, Ази тивийг энх тайван, тогтвортой байдлын бүс болгох талаар ЗХУКН-ын XXIV, XXV, XXVI их хурлуудаас дэвшүүлсэн 80-аад оны энх тайвны программын үзэл санааг хэрэгжүүлэхэд уг санаачлага шууд чиглэсэн бөгөөд тэр нь туйлын буурьтай, туйлын ажил хэрэгч алхам юм. Нөхөр Л. И. Брежнев хэлсэн үгэндээ Азийн томоохон гурван гүрэн Бүгд Найрамдах Энэтхэг улс, Бүгд Найрамдах Хятад ард улс, Япон улстай ЗХУ-ын харилцах харилцааны байр суурийг тодорхойлж өгөв.

ЗХУ, БНЭУ-ын найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэн гүнзгийрүүлэхийн төлөө хорин таван жил гаруй цуцалтгүй идэвхтэй ажилласны үр дүнд Зөвлөлт-Энэтхэгийн харилцаа их амжилтанд хүрч, тэр нь Зөвлөлт-Энэтхэг хоёр орон, тэдгээрийн удирдагчдын хоорондын харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэснийг нөхөр Л. И. Брежнев онцлон тэмдэглээд Зөвлөлт-Энэтхэгийн харилцаа нь нийгмийн өөр өөр байгуулал бүхий улс орнууд энх тайвнаар зэрэгцэн оршиж, ха-

⁴«Үнэн» 1981. VI. 30.

⁵«Үнэн» 1981. IX. 27.

⁶Мөн тэнд

рилцаагаа янз бүрийн салбарт амжилттай хөгжүүлж болохын сайхан үлгэр дууриал болж байна гэж үнэлсэн юм.

Дэлхийн II дайны жилүүдэд Алс Дорнодод Японы милитаризм Ази тивийн олон улс орны соёл, иргэншлийг үнсэн товрог болгох дайнч бодлогыг явуулж байсан нь зөвхөн Японы ард түмэн төдийгүй, милитаристуудын бодлогод нэрвэгдэж байсан олон орны ард түмний бодол санаанаас өнөө болтол гараагүй байгаа юм.

Японы милитарист бүлгийнхний цэрэг дайны бодлогыг хазаарлан зогсоох, Алс Дорнодод итгэлцлийн уур амьсгалыг бий болгох явдал бол Ази тивд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах нийтийн үйлсэд чухал нэмэр хандив оруулах ёстой.

Нөхөр Л. И. Брежнев ЗХУ, Японы харилцааг цаашид сайн хөршийн найдвартай шинж чанартай болгох, Зөвлөлт-Японы харилцааг хөгжүүлэх нь хоёр орны ард түмний болон энх тайван, аюулгүй байдлын эрх ашигт бүрэн нийцэх юм гэдгийг цохон заагаад Зөвлөлт Холбоот улс, Япон хоёр эдийн засаг, худалдааны харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь давын түрүүнд Японы үндэсний эрх ашигт нийцэх юм. Японы милитарист бүлгийнхэн гаднын түлхээсээр Японыг Зөвлөлтийн эсрэг турхирч, «Умардын аюул» гэдэг нэрийн дор Япон-Зөвлөлтийн харилцаанд саад хориг тавихыг санаархаж байгаа нь Японы үндэсний язгуур ашиг сонирхолд төдийгүй, Азид аюулгүй байдлыг хамгаалах, итгэлцлийн уур амьсгалыг бий болгоход ноцтой саад тотгор болж байгаа юм. Тиймээс ч нөхөр Л. И. Брежнев «Бид Япон улстай сайн хөршийн найдвартай харилцаатай байж, харилцан ашигтай хамтран ажиллах, харилцан итгэлцэхийг хүсч байна»⁷ гэж цохон тэмдэглээд «харилцан болгоомжилж, сэтгэл түгшиж байгаа зүйлээ хэлэлцэж, итгэлцлийг бэхжүүлэх талаар хоёр талын аль аль нь хүлээн зөвшөөрч болох арга хэмжээний талаар тохиролцох тухай нэг жилийн өмнө дэвшүүлсэн зөвлөлтийн саналыг дахин цэгнэж үзэхийг Японы талд уриалсан билээ.

Хятадын эрх баригчдаас Зөвлөлтийн эсрэг, энх тайвны эсрэг ажил явууллагаа урьдын адил үргэлжлүүлж буй өнөөгийн нөхцөлд ЗХУКН-ын XXIV, XXV, XXVI их хурлуудаас Зөвлөлт-Хятадын харилцааны талаар өгсөн зарчмын чиг шугамд тулгуурлан Л. И. Брежнев Зөвлөлт Хятадын харилцааны одоогийн бодит байдалд дүн шинжилгээ хийж хоёр улсын харилцааг хэвийн болгох талаар туйлын буйр суурьтай, олон талаас нь цэгнэн бодсон оновчтой санал дэвшүүлсэн нь зөвхөн Азийн төдийгүй дэлхийн олон нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж тэдний нааштай өндөр үнэлгээ дэмжлэг хүлээж байна. Нөхөр Л. И. Брежневийн энэ шинэ санаачлага нь Зөвлөлт Холбоот улсын энх тайвныг тууштай эрхэмлэдэг гадаад бодлогын бас нэг яруу тод илрэл боллоо. Нөхөр Л. И. Брежнев Хятадын өнөөгийн байдлын талаар дүгнэн өгүүлсэн нь: «...Бээжингийн эрх баригчид олон улсын тавцан дээр империалистуудын бодлоготой хүзүү холбож байгаа нь мэдээжээр социализмын эрх ашигт харшилж байгаа боловч хятадад нийгмийн социалист байгуулал байгааг бид хэзээ ч үгүйсгэж байгаагүй одоо ч үгүйсгээгүй байна» гэжээ. Ийнхүү нөхөр Л. И. Брежнев Зөвлөлт, Хятадын харилцааг хэвийн болгох бодит үндэс суурь одоо ч хэвээр байгааг нотолсон зарчмын чухал ач холбогдолтой дүгнэлт хийжээ.

Америкийн нэгдсэн улсын одоогийн засаг захиргаа Тайваньд орчин үеийн зэр зэвсэг нийлүүлэн, түүнийг Азид явуулж буй цэрэг-стратегийн бодлогодоо цаашид ч ашиглах гэж чармайн улмаар «Хоёр Хятад» гэгч баримтлалыг БНХАУ-д тулган хүлээлгэх гэж оролдож байгаа

одоо үед нөхөр Л. И. Брежнев «хоёр Хятад» гэгч баримтлалыг ЗХУ ямар ч хэлбэрээр хэзээ ч дэмжиж байгаагүй, одоо ч дэмжээгүй байгаа бөгөөд БНХАУ Тайвань арлыг харъяалах бүрэн эрхтэйг бид бүрэн зөвшөөрч ирсэн, одоо ч зөвшөөрч байна»⁸ гэж хэлсэн нь Зөвлөлтийн интернационалч зарчимт байр суурийг дахин нотолсон чухал зүйл мөн.

ЗХУ-ын зүгээс БНХАУ-д ямарч аюуд занал учруулж байгаагүй, одоо ч учруулаагүй байна. Хоёр орны хооронд нутаг дэвсгэрийн талаар ямар ч гомдол байгаагүй, одоо ч байхгүй байна гэдгийг иш үндэс болгон аль аль тал нь хүлээн зөвшөөрч болохуйн шийдвэр гаргахын тулд хилийн одоо байгаа асуудлаар хэлэлцээгээ цаашид үргэлжлүүлэх, мөн Зөвлөлт, Хятадын хилийн районд харилцан итгэх явдлыг бэхжүүлэх талаар авч болох арга хэмжээний тухай асуудал хэлэлцэхэд ЗХУ-ын тал бэлэн байгаагаар илэрхийлсэн явдал нь Зөвлөлт-Хятадын хилийн асуудлыг оруулан харилцаагаа сайжруулахыг ЗХУ чин сэтгэлээсээ эрмэлзэж байдгийн нэг тод жишээ юм.

Үүнд онцлон тэмдэглэвээс зохих нэг зүйл нь Зөвлөлт, Хятадын Харилцааг сайжруулахдаа ямарваа нэгэн гуравдахь орны эрх ашгийг үл хохироох хоёр талын аль аль нь зөвшөөрч болох арга хэмжээний тухай ямарваа урьдчилсан болзол тавилгүйгээр хэлэлцэн тохиролцох үндсэн зарчмыг нөхөр А. И. Брежнев яруу тодоор томьёолсон явдал мөн.

ЗХУ, БНХАУ-тай энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр давын түрүүнд улс төрийн харилцаанд тодорхой алхам хийхэд бэлэн болсны тэр хэмжээгээр эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын харилцааны салбарт хамтран ажиллах хүсэл эрмэлзлэл төгс байгаагаар илэрхийлсэн байна.

Зөвлөлтөөс Азийн гурван том улстай харилцах харилцааны талаар Ташкентэд нөхөр Л. И. Брежневийн хэлсэн үг нь туйлын өргөн агуулгатай бөгөөд Ази дахинд энх амгалан байдал, хамтын ажиллагаа, харилцан итгэлцэх уур амьсгалыг нийтийн чармайлтаар бэхжүүлэх шийдвэр төгөлдөр байгаад дэлхийн олон нийт баяр хүргэж байна.

Харамсалтай нь Хятадын эрх баригчид н. Л. И. Брежневийн энэ оновчтой шинэ санаачлагыг зөвлөлтийн эсрэг үзэл бодлын үүднээс «дүгнэн» жадлан эсэргүүцэж байна. Жэньминь жибао сонинд⁹ нийтлэгдсэн Синьхуа хорооны тайлбарлагчийн өгүүлэлд Л. И. Брежневийн Ташкентэд хэлсэн үгийг Зөвлөлт Холбоот Улс хятадын дотоод хэрэгт хөндлөн- гөөс оролцож дэлхийд жанжлах, түрэмгийлэн эзлэх бодлого явуулж байгаа мэтээр мушгин гуйвуулж бичсэн байна. Хятадын эрх баригчдын одоогийн үйл ажиллагаанаас үзэхэд Бээжингийн удирдлага Зөвлөлт, Хятадын харилцааг сайжруулахтай холбогдсон зөвлөлт засгийн газрын энэ удаагийн оновчтой, зарчмын саналыг ч анхааралдаа авахгүй эсэргүү- цэж байгаа нь илт байна.

Гэтэл нөхөр Л. И. Брежневийн утга төгөлдөр зарчмын үгийг дэлхий дахины энхийг эрхэмлэгч бүх хүчин түүний дотор Монголын өргөн олон нийт, аливаа асуудлыг бодит байдал, эрүүл саруул ухаанаар дүгнэн цэгнэж чаддаг, улс төр, олон нийтийн зүтгэлтнүүд анхааралтай судалж энх тайван, олон улсын аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэсэн чухал алхам гэж үзэж баяр хүргэн дэмжсэн өргөн хөдөлгөөн өрнөсөөр байна.

⁸«Үнэн» 1982. III. 26.

⁹«Жэньминь жибао» 1982. III. 27.

МНР В БОРЬБЕ ЗА МИР И БЕЗОПАСНОСТЬ В АЗИИ

Р е з ю м е

Одной из основных задач миролюбивой внешней политики МНР является обеспечение и сохранение мира и безопасности в Азии. Эта задача полностью соответствует общей миролюбивой политике братских социалистических стран, направленной на смягчение международной напряженности. На XVIII съезде МНРП, состоявшемся в мае 1981 года, была выдвинута принципиальная инициатива выработать и подписать конвенцию о взаимном ненападении и неприменении силы в отношениях между странами Азии и Тихого океана.

Для претворения в жизнь этого предложения, на сессии Великого Народного Хурала в июне 1981 года было принято обращение к парламентам всех азиатских стран и государств бассейна Тихого океана, в котором прозвучал призыв объединить усилия народов для укрепления мира и устранения войны.

Для принятия практических шагов по реализации предложения МНР. Генеральный секретарь ЦК МНРП, Председатель Великого Народного Хурала тов. Ю.Цеденбал обратился со специальным посланием к главам государств Азии и бассейна Тихого океана. Авторы статьи особо отмечают актуальность и практическую значимость этих мероприятий в нынешней международной обстановке в Азии.

Монгольский народ целиком и полностью поддерживает мирные инициативы, с которыми выступают Советский Союз и другие социалистические страны. В этой связи подчеркивается международное значение выступления тов. Брежнева на торжественном заседании в Ташкенте. Речь советского руководителя содержала конкретные предложения по укреплению мира и безопасности, распространению мер взаимного доверия и развитию сотрудничества и добрососедских отношений между азиатскими странами в первую очередь, 3-мя крупнейшими азиатскими державами-Индией, Японией и КНР.

Авторы отмечают, что высказывания тов. Брежнева относительно Китая подтверждают принципиальную позицию Советского Союза в отношении КНР и полностью отвечают жизненным интересам народов не только обеих стран, но и всех стран Азии. Вместе с тем авторы критикуют негативную позицию Пекина в отношении конкретных предложений Советского Союза по улучшению добрососедских отношений с Китаем.

Миролюбивая мировая общественность, в том числе и монгольский народ, высоко оценили новый шаг СССР на пути к обеспечению мира в Азии